

ӨГҮҮЛЭЛ

Монгол-Оросын худалдаанд гарч буй өөрчлөлтүүд ба тэдгээрийн зүй тогтол

Авирмэдийн Даваасүрэн 

Доктор (Sc.D), профессор

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

davaasurena@mas.ac.mn

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол, Оросын худалдааны түүхэн ба өнөө цагийн чиг хандлага, түүний зүй тогтол, нөлөөлж буй объектив хүчин зүйлс, Монгол Улсын экспортын чадавхи болон импортын гол нэр төрөл барааны тоо хэмжээ ба үнийн дүнгийн ерөнхий динамикт Ковид-19 цар тахалын үзүүлсэн нөлөө, Монгол Улсын экспорт болон импортын барааны бүтэц, Монгол, Оросын хил орчмын худалдаанд Эрхүү муж, Буриад Улс, Алтайн болон Красноярскийн хязгаар зэрэг субъектүүдийн гүйцэтгэж байгаа үүрэг, Монгол Улстай шууд залгаа хиллэдэг субъектүүд ба шууд хиллэдэггүй субъектүүдтэй хийж байгаа худалдаан дахь харьцааны өөрчлөлт, хил орчмын худалдаан дахь субъектүүдийн тодорхой төрлийн бараан дээр дагнаж, төрөлжсөн байдлыг бичсэн.

Түлхүүр үгс: Монгол, Орос, худалдаа, экспорт, импорт, жонши, газрын тос, эрчим хүч, мах махан бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, хил орчмын худалдаа гэх мэт.

Нэг. Монгол, Оросын худалдааны нөхцөл байдал


Монгол, Орос хоёр улсын арилжаа, худалдааны харилцаа нь өнө эрт дээр үеэс эхэлсэн түүхэн баялаг уламжлалтай билээ. Хоёр улсд он удаан жилүүдийн туршид хаяа хаяагаа дэрлэн зэрэгцэн оршиж хүссэн ч эс хүссэн ч худалдаа наймааны харилцаанд орж бие биенийхээ хэрэгцээг хангаж ирсэн. Адам Смитын “Харьцангуй давуу талын” онолын дагуу Монгол улс мал аж ахуйн түүхий эд болох

ноос, ноолуур арьс шир, ангийн үсийг ОХУ-д нийлүүлээд оронд нь хүнсний бараа болон өргөн хэрэглээний барааг авч өөрсдийнхөө хэрэгцээг хангах ирсэн уламжлалтай билээ.

1990 оноос хойш Монгол, Орос улс хоорондох худалдаа, эдийн засгийн харилцааны цар хүрээ жилээс жилд улам хумигдах боллоо. Зураг 1-ээс харна уу.



Зураг 1. Монгол, Оросын гадаад худалдааны байдал, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны жил тутамын статистикийн эмхэтгэл, 2005-2023, www.l212.mn

Зураг 1-ээс харахад 1989 онд тус тус эзэлж байлаа. Тэгвэл 1990 оноос Монгол Улсын гадаад худалдааны хойш хоёр улсын гадаад худалдааны бүтцэд ЗХУ 78,8 хувийг эзлэж байхад үзүүлэлтүүд огцом унаж иржээ. экспорт 78,3 хувь, импорт 82,7 хувийг

Хүснэгт 1. Монгол, Оросын худалдааны өнөөгийн байдал, сая ам доллар

Он	Гадаад худалдааны нийт эргэлт	Экспорт	Импорт	Худалдааны алдагдал
2005	445,2	27,2	417,9	-390,7
2006	592,9	45,1	547,8	-502,7
2007	803,5	58,5	745,0	-686,5
2008	1328,6	86,3	1242,3	-1156,0
2009	841,0	68,2	772,8	-704,6
2010	1129,4	82,7	1046,7	-964,0
2011	1721,0	96,3	1624,7	-1528,4
2012	1927,0	79,6	1847,4	-1767,8
2013	1623,6	61,8	1561,9	-1500,1
2014	1610,9	61,6	1549,3	-1487,7
2015	1097,9	76,9	1021,0	-944,1
2016	936,2	55,8	880,4	-824,6
2017	1284,9	67,7	1217,3	-1149,6
2018	1796,3	85,9	1710,3	-1624,4

2019	1798,0	68,1	1729,9	-1661,8
2020	1457,2	57,3	1400,0	-1342,7
2021	2068,0	112,8	1955,2	-1842,4
2022	2704,9	93,4	2611,5	-2518,1
2023	2499,0	112,7	2386,3	-2273,6

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны жил тутамын статистикийн эмхэтгэл, 2005-2023, www.1212.mn


Хүснэгт 1- ээс харахад хоёр талын худалдаанаас Монгол Улсын хүлээх алдагдал буурахгүй байна. Монгол Улсын ОХУ-руу хийж байгаа экспорт үндсэндээ зогссон байна. Энэ нь ОХУ-ын дотоодын тээврийн өндөр зардал, ЕвроАзийн эдийн засгийн холбооны тарифын болон тарифын бус хориг саадаас шатгаалж байна. Тухайлбал, Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүнд оросын талаас тавьж буй эрүүл ахуй

хорио цээрийн хатуу дүрэм журамтай холбоотой бөгөөд нөгөө талаас, ОХУ-ын зах зээлийг хангах үйлдвэрлэлийн хүчин чадал, махны нөөц манай улсын хувийн жижиг мах комбинатуудад байхгүй, тэдгээрийн мах бэлтгэл нь зөвхөн малчдын малны борлуулалтаас шалтгаалдаг тул мах бэлтгэл тогтмол биш байдаг нь тус улсын зах зээл дээр монгол махны экспортын барааны өрсөлдөх чадварыг бууруулж байна.

1.1. ОХУ руу хийсэн Монгол Улсын экспортын зарим барааны нөхцөл байдал

Монгол Улсын хайлуур жоншны бүтээгдэхүүний гол хэрэглэгч нь ОХУ болон тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд бөгөөд эдгээр

орнуудын хөнгөн цагаан, хими болон металлургийн үйлдвэрүүдэд ашиглах зориулалтаар импортоор авдаг.




Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистикийн мэдээллийн сангийн тоо баримт дээр тулгуурлан тооцов, <http://www.customs.gov.mn/>

Зураг 2-оос харахад Монгол Улс 2014 онд 179 мянган тн хайлуур жоншийг ОХУ руу экспортлож байсан бол 2018 онд 189 мянган тн хүртэл өсөхөд дэлхийн ган хайлуулах үйлдвэрлэл эерэг нөлөө үзүүлсэн байна. Гэвч Ковид-19 цар тахалын үед 2022 онд 178 мянган тн жонш экспортлосон байна. Энэ нь ОХУ-ын ихэнхи гангийн үйлдвэрлэлийн уналт, төмөр замын тээврийн өндөр зардал зэргээс шалтгаалан жоншны

экспортын хэмжээ хэлбэлзлэлтэй байна.

Монгол Улсын ОХУ руу нийлүүлж буй экспортын өөр нэг чухал бүтээгдэхүүн бол мах, махан бүтээгдэхүүн юм. 2014-2023 онд манай экспортын мах, махан бүтээгдэхүүний хэмжээ харьцангуй их байсан бол Ковид-19 цар тахалын үед зогсонги байдалд орж, улмаар 2022 оноос бага зэрэг өсөж 2023 онд 704,9 тн болсон байна.



Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистикийн мэдээллийн сангийн тоо баримт дээр тулгуурлан тооцов, <http://www.customs.gov.mn/>

Хэдийгээр ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын хэрэглэгчид манай махыг хэрэглэхийг хүсдэг боловч махны экспортыг нэмэгдүүлэх тал дээр бодитой үр дүн гарахгүй байна. Энэ нь махны импортын төлбөрийг дараа төлбөрт нөхцөлөөр хийдэгээс шалтгаалж манай экспортлогчид эргэлтийн хөрөнгийн дутагдалд ордог байна. Нөгөө талаас 2019-2021 онд

манай улсын махны экспортын хэмжээ бараг зогсоход Ковид-19 цар тахал сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Монгол Улсын экспортод мал аж ахуйн гаралтай түүхий эд болох хонины ноос, ямааны ноолуур болон тэмээний ноос, ангийн үс, арьс шир, тэдгээрээр хийсэн эцсийн болон хагас боловсруулсан бараа, бүтээгдэхүүн чухал байр суурийг эзлэж байна.

Хүснэгт 2. ОХУ руу оруулсан Монгол Улсын экспортын барааны бүтэц, хувиар

Он	Хайлуур жонш	Мах, махан бүтээгдэхүүн	Ноос, ноолуур, ангийн үсээр хийсэн эдлэл, хивс	Бусад бараа, бүтээгдэхүүн
2014	60,7	9,6	2,7	26,9
2015	45,5	8,5	2,0	44,0
2016	70,0	9,8	3,7	16,4
2017	70,0	8,8	4,5	16,6
2018	72,9	6,2	3,1	17,7
2019	72,6	1,5	3,6	22,3
2020	77,9	0,14	3,2	18,7
2021	40,6	0,1	3,1	56,1
2022	50,2	4,6	2,6	42,5
2023	42,0	2,2	2,8	52,9

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээлэл, <http://www.1212> болон Гаалийн Ерөнхий газрын гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл дээр үндэслэн тооцов. <http://www.customs.gov.mn/>

Хэдийгээр Монгол Улсад малын байгаа ч гэсэн үндэсний үйлдвэрүүдэд гаралтай түүхий эдийг боловсруулж анхан шатны боловсруулалт хийж бэлэнбүтээгдэхүүнүйлдвэрлэхтуршлага чадахгүй, түүхий эдээ хаясаар байна.

1.2. ОХУ-аас оруулсан Монгол Улсын импортын зарим барааны нөхцөл байдал

Монгол Улс дотоодын хэрэгцээний шатах тослох материалын дийлэнхийг газрын тосны бүтээгдэхүүн болох ОХУ-аас импортоор авч байна. автобензин, дизелийн ба онгоцны түлш,



Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистикийн мэдээллийн сангийн тоо баримт дээр тулгуурлан тооцов, <http://www.customs.gov.mn/>


Зураг 5-аас харахад 1999 онд 368,5 мянган тн газрын тосны бүтээгдэхүүн импортоор авч байсан бол 2010 онд 792,4 мянган тн буюу 2,1 дахин, 2023 онд 2164,3 мянган тн буюу 5,8 дахин өссөн байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ жил бүр нэмэгдэх болсон нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж үүнийг даган тухайн үйлдвэрлэлийн зориулалтаар импортлогдож байгаа машин, техник хэрэгслийн импорт нэмэгдэж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Импортын газрын тосны бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт нь дотоодын зах зээл дээрхи өргөн хэрэглээний барааны үнэ, ханшид хүчтэй нөлөө үзүүлдэг учраас зөвхөн нэг улсаас хараат байдлыг өөрчилж

олон эх үүсвэртэй болгох чиглэлээр анхаарч ажиллах шаардлага зүй ёсоор гарч байна.

ОХУ-аас импортоор оруулж ирж байгаа бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүн дотор гурил, будаа, ургамлын тос нь Монгол Улсын дотоод зах зээлийг нэн шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Тухайлбал, 2014 онд 12,2 сая тн гурил, 2016 онд 24,8 сая тн гурил болж өсөж байсан бол 2017 онд 1,3 сая тн гурил болж буураад 2023 онд өсөж 12,8 сая тн болсон байна. Энэ нь ОХУ-ын хүнсний бүтээгдэхүүний ялангуяа гурил, будааны экспортын бодлогын өөрчлөлт, дэлхийн зах зээл дээрхи үнэ ханш нь манай улсын дотоод зах зээлийн эрэлт, хэрэглээний үнэ ханшийг өөрчлөхөд хүргэдэг зүй тогтолтой байна.

Зураг 6. ОХУ-аас оруулсан импортын гурил, будаа, ургамалын тосны импортын хэмжээ, сая тн



Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистикийн мэдээллийн сангийн тоо баримт дээр тулгуурлан тооцов, <http://www.customs.gov.mn/>


Монгол Улсын импортод ОХУ-ын ургамалын тос чухал байр суурийг эзлэж

байна. Тухайлбал, 2014 онд Монгол Улс ОХУ-аас 16,8 сая тн ургамалын тос

импортлож байсан бол 2020 онд 27 сая тн-д хүрч өсөөд 2023 онд 20,8 сая тн болсон байна.

Тэгвэл Монгол Улсын төвийн эрчим хүчний систем, баруун бүсийн эрчим хүчний систем нь ОХУ-ын Буриад улсын Галуут нуурын цахилгаан станц болон Алтайн бүгд найрамдах улсын эрчим хүчний системээр дамжуулж

цахилгаан эрчим хүч импортоор авч байна. 2014 онд ОХУ-аас импортоор авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ 421 МВт байсан бол 2023 онд 905 МВт болж 2,1 дахин өссөн байна. Үүнд Монгол Улсын дотоодын цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт нөлөөлсөн байна.



Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистикийн мэдээллийн сангийн тоо баримт дээр тулгуурлан тооцов, <http://www.customs.gov.mn/>

ОХУ-аас Монгол Улс импортын эрчим хүчний 80 хувийг төвийн эрчим хүчний системээр, 20 хувийг баруун бүсийн эрчим хүчний системээр дамжуулан авч байна. Монгол Улсын

нийт импортод цахилгаан эрчим хүч 2014 онд 2 хувийг эзлэж байсан бол 2023 онд 2,43 хувийг эзлэж бага зэрэг өссөн байна¹.

Хүснэгт 3. ОХУ-аас оруулсан Монгол Улсын импортын барааны бүтэц, хувиар

	Газрын тосны бүтээгдэхүүн	Цахилгаан эрчим хүч	Хүнсний бүтээгдэхүүн	Бусад бараа, бүтээгдэхүүн
2014	64,7	2,1	1,6	31,6
2015	63,6	1,7	2,5	32,1
2016	53,7	2,4	3,5	40,5
2017	60,8	2,1	2,5	34,6
2018	60,8	1,6	1,7	35,9
2019	62,0	1,6	1,2	35,1

¹ Монгол Улсын Эрчим хүчний статистикийн үзүүлэлт, Монгол Улсын Эрчим Зохицуулах хороо, 2023, <https://erc.gov.mn/web/mn/statistic>

2020	51,8	1,5	2,2	44,5
2021	51,3	1,7	2,0	45,0
2022	60,6	2,0	1,6	35,8
2023	70,9	2,4	1,1	25,6

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээлэл, <http://www.1212> болон Гаалийн Ерөнхий газрын гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл дээр үндэслэн тооцов. <http://www.customs.gov.mn/>

Монгол Улсын ОХУ-тай хийж байгаа худалдаа нь гадаад зах зээл болон түүн дээрхи үнэ, ханшны уналтаас хамаарч экспортын орлого эрс буурдаг, импортын зардал нэмэгддэг зүй тогтолтой байна. Импорт нь экспортоос илүү хурдтай өсч байгаа нь нефтийн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн, цахилгаан эрчим хүч, машин, техник хэрэгслийн импорт нэмэгдэж, хэрэглээ өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

Монгол Улсын ОХУ руу хийж байгаа экспортын бүтцэд хайлуур жонш, мах махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур,

арьс шир, мал амьтаны үсээр хийсэн бүтээгдэхүүн зэрэг цөөхөн нэр төрлийн бараа голлох байр суурийг эзлэж байгаа бол импортын бүтцэд тус улсын газрын тосын бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, цахилгаан эрчим хүч, автомашин, нийтийн тээврийн хэрэгсэл зэрэг бараа голлох байр суурийг эзлэж байна. Манай улсын экспортын бүтэц дэхь түүхий эдийн хувийн жинг багасгах бэлэн бүтээгдэхүүний хувийн жинг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Хоёр. Монгол, Оросын хил орчмын худалдааны нөхцөл байдал

2021 оны ОХУ-ын албан ёсны статистикийн мэдээнд тус улстай хийж байгаа худалдааны эргэлт 1859,1 сая ам долларт хүрсэн байна. Үүнээс ОХУ-ын экспортын (Монгол Улсын импорт) бараа 1816,0 тэрбум сая ам доллар, импортын (Монгол Улсын экспорт) бараа 43 сая доллар болжээ.

Тэгвэл 2021 онд Монгол Улсын хилийн дагуу байршилтай ОХУ-ын субъектуудын худалдааны эргэлт 221,1 сая ам доллар болсон бол экспортын хэмжээ 211,6 сая ам доллар, импортын хэмжээ 9,5 сая ам доллар болсон байна. Өөрөөр хэлбэл Монгол, Оросын хил орчмын худалдааны квотод экспортын квот 95,7 хувь, импортын квот 4,3 хувийг тус эзлэж байна.

Хүснэгт 4-өөс харахад Монгол, Орос улс хоорондын худалдааны нийт эргэлтэд хил орчмын худалдаа 11,9 хувь, үүнээс экспорт 11,6 хувь, импорт 22,1 хувийг тус тус эзлэж байна. Өөрөөр хэлбэл Монгол, Оросын худалдаанд хил орчмын субъектүүдтэй хийж байгаа худалдаа дөнгөж 11,9 хувийг эзлэж байгаа бол Монгол Улстай шууд хиллэдэггүй бусад субъектүүдтэй хийж байгаа худалдаа 88,1 хувийг эзлэж байна.

Монгол, Оросын хил орчмын худалдааг субьектээр нь авч үзвэл 2021 онд худалдааны нийт эргэлтэд Эрхүү муж 4,5 хувийг эзлэж хил орчмын худалдаанд Эрхүү муж хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Тэгвэл

Хүснэгт 4. 2021 оны байдлаар ОХУ-ын Монгол Улстай хийж байгаа хил орчмын худалдааны үзүүлэлт, мянган ам доллар

№		Гадаад худалдааны эргэлт		Экспорт		Импорт	
	Монгол Улс	1859141,9	100	1816074,1	100	43067,8	100
	Хил орчмын худалдаа	221147,5	11,9	211617,8	11,6	9529,7	22,1
1	Үүнээс: Эрхүү муж	84951,0	4,5	83117,2	4,5	1833,8	4,3
2	Буриад улс	56756,1	3,0	54103,7	2,9	2652,3	6,1
3	Алтайн хязгаар	41698,5	2,2	41127,3	2,2	571,2	1,3
4	Красноярскийн хязгаар	29154,4	1,5	27437,4	1,5	1717,0	4,0
5	Хакас улс	4250,0	0,23	4189,0	0,23	61,0	0,1
6	Алтай улс	1790,4	0,1	660,0	0,03	1130,4	2,6
7	Арбайгалийн хязгаар	1733,5	0,09	237,0	0,01	1496,5	3,5
8	Тува улс	813,7	0,04	746,2	0,04	67,5	0,2

Тайлбар: 2022 оноос хойшхи ОХУ-ын засгийн газар Орос, Украины дайны үйл ажиллагаанаас шалтгаалсан статистикийн мэдээллийг бүрэн хориглосон тул өөрт олдсон статистикийн бүрэн бус мэдээлэл дээр тулгуурлаж шинжилгээ хийлээ.

Эх сурвалж: <https://russian-trade.com/statistics/by-country/mongolia/2021/>

Буриад улс 3 хувь, Алтайн хязгаар 2,2 хувь, Красноярскийн хязгаар 1,5 хувь, Алтай улс 0,1 хувийг тус эзлэсэн байна.

Красноярскийн хязгаар нь Монгол Улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдаанд чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, 2021 онд Красноярскийн хязгаар, Монгол Улс хоорондын худалдааны эргэлт 29,1 сая ам долларт хүрсэн байна. Үүнээс Красноярскийн хязгаараас Монгол Улс руу 27,4 сая ам долларын бараа экспортлож, 1,7 сая ам долларын бараа импортоор авсан байна. Красноярскийн хязгаарын аж үйлдвэрийн барааны экспорт нь хоёр улсын худалдаанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

ОХУ-ын хил орчмын субъектүүдээс манай улсын импортод Буриад улс хүнсний бараа, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, мод, модон эдлэл, Эрхүү муж эрдэсийн

бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн, хуванцар, каучукаар хийсэн эдлэл хэрэгсэл, төмөрлөгийн бүтээгдэхүүн, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл хэрэгсэл, мод, модон эдлэл, барилгын материал, Красноярск хязгаар хүнсний бараа, Алтайн хязгаар эрдэсийн бүтээгдэхүүн, хүнсний бараа, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн экспортоор тэргүүлж байна.

Тэгвэл ОХУ-ын хил орчмын субъектүүд руу гаргасан Монгол Улсын экспортод Буриад улс хүнсний бараа, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, арьс шир, ноос, ноолуур, ангийн үсээр хийсэн хувцас, Эрхүү муж машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, төмөрлөгийн бүтээгдэхүүн, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, барилгын материал, Красноярск хязгаар хүнсний бараа, химийн бүтээгдэхүүн, хуванцар,

каучукаар хийсэн эдлэл, төмөрлөгийн бүтээгдэхүүн, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, мод, модон эдлэл, Тува

улс шир, ноос, ноолуур, ангийн үсээр хийсэн хувцасны импортоор тэргүүлж байна.

Гурав. Дүгнэлт

Өнгөрсөн хугацаанд Монгол, Оросын худалдаанд оролцогч субъектүүд болон барааны нэр төрөл, тоо хэмжээнд өөрчлөлтүүд гарч байна. Хоёр талын худалдааны эргэлтийн хэмжээ 1990 оны хэмжээнд хүрч чадаагүй байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын экспортын бараа, бүтээгдэхүүний нэр төрөл тоо хэмжээ багасаж байхад тус улсаас авч байгаа Монгол Улсын импортын бараа, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ өсөж байдаг зүй тогтолтой байна. Өөрөөр хэлбэл ОХУ-тай хийж байгаа худалдаа Монгол Улсад алдагдалтай хэвээр байна.

Тэгвэл Монгол, Оросын хил орчмын худалдаанд Эрхүү муж, Буриад улс, Красноярскийн хязгаар

зэрэг субъектүүдын газрын тос, аж үйлдвэрийн болон хүнсний барааны экспорт чухал үүрэг гүйцэтгэж байхад Монгол Улсын Буриад, Тува руу оруулсан арьс шир, ноос, ноолуур, ангийн үсээр хийсэн хувцасны экспорт чухал үүрэг гүйцэтгэж байна.

Иймд цаашид Монгол, Оросын хоорондын болон хил орчмын худалдааг тэнцвэртэй болгох, Монгол Улсын экспортын барааны нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдүүлэх, боловрсуулалтын түвшинг дээшлүүлэх, тэдгээрийн зах зээлийн үнэ ханшны өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг бууруулах, хүнсний зарим барааны импортыг орлох үйлдвэрлэлийг Монгол Улсад хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

Ном зүй / References:

1. А.Даваасурэн, С.Нямзагд, В.И.Самаруха, “ОХУ, Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагаа: уламжлал, эдүгээ ба ирээдүй” /эрдэм шинжилгээний өгүүлэл/ 2021 оны 10 сарын 19-ий өдөр ГХЯ дээр зохион байгуулагдсан “Монгол-Оросын харилцаа 100 жилд” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Монгол банкны “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл, № 26 (2021 оны 10 дугаар сар), Улаанбаатар, х 171-183, 1,06 х.х.
2. А.Даваасурэн, “Монгол-Оросын худалдаа, бизнесийн хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд” МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулиас 2017 оны 12 сарын 15-д зохион байгуулсан “Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын итгэлүүд, Улаанбаатар хот, тусгай дугаар, х-84-89,
3. Объективная необходимость увеличения экспорта кашемировых изделий путем развития малого и среднего бизнеса / А. Даваасурэн //Проблемы регулирования внешнеэкономической деятельности в условиях вступления России в ВТО: материалы науч.-практ. конф.:посвящ. 60-летию Иркут. тамож. и 20-летию Сиб. тамож. Управления, Иркутск, 23-24 мая 2012г. Иркутск : Из-во БГУЭП, 2012.
4. “Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд” / Хамтын бүтээл, төслийн удирдагч А.Даваасурэн, Хөгжлийн бодлогын судалгааны хүрээлэн, “Бэмби сан” хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2020,14,75 х.х.
5. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээлэл, <http://www.1212>
6. Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл, <http://www.customs.gov.mn/>
7. ОХУ-ын Гадаад худалдааны статистикийн мэдээлэл, <https://russian-trade.com/statistics/by-country/mongolia/2021/>
8. Монгол Улсын Эрчим хүчний статистикийн үзүүлэлт, Монгол Улсын Эрчим Зохицуулах хороо, 2023, <https://erc.gov.mn/web/mn/statistic>

Changes and Patterns in Mongolia-Russia Trade

Davaasuren Avirmed

Sc.D

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
davaasurena@mas.ac.mn*

Abstract: *This article examines the historical and contemporary trends in Mongolia-Russia trade, their patterns, and the objective factors influencing them. It also analyzes the impact of the COVID-19 pandemic on the overall dynamics of Mongolia's export potential and the quantity and value of key imported goods. The article explores the structure of Mongolia's exports and imports, the role of regions such as Irkutsk Oblast, the Republic of Buryatia, Altai Krai, and Krasnoyarsk Krai in Mongolia-Russia border trade, as well as changes in trade relations between directly adjacent Russian regions and those without direct borders with Mongolia. Additionally, it highlights the specialization and diversification of certain types of goods in border trade between these regions.*

Keywords: *Mongolia, Russia, trade, export, import, fluorspar, oil, energy, meat and meat products, food products, border trade.*

<i>The day of submission:</i>	<i>2024.10.09</i>
<i>Completion of Review:</i>	<i>2024.11.24</i>
<i>Final Decision for Acceptance:</i>	<i>2024.12.26</i>